



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Чингис хот

Хохирогч, иргэний нэхэмжлэгч
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өндөрхаан хот тохижилт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт тусгай зориулалтын автомашины тендерт сонгон шалгаруулалтанд оролцсон “Алсын солонго” ХХК нь ажил үйлчилгээ хийх боломжгүй эвдэрсэн хуучин машин нийлүүлсэн гэх бүртгэлийн 000470 дугаартай гомдолд хохирогч, иргэний нэхэмжлэгчээр “Өндөрхаан хот тохижилт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Э.Мөнхбатыг томилсугай.

2. Цагдаагийн газарт шалгагдаж байгаа бүртгэлийн 0004470 дугаартай хэрэгт холбогдох нотлох бичиг баримтыг гарган өгч ажиллахыг “Өндөрхаан хот тохижилт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Э.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР